

**Петро Матад Лимитед ("Петро Матад" эсвэл "Компани" гэх)
Үйл ажиллагааны шинэчилсэн мэдээлэл**

Петро Матад компани нь Монгол орны зүүн хэсэгт байрлах, Бүтээгдэхүүн Хуваах Гэрээт ("БХГ" гэх) Матад ХХ талбай дахь Давсан Толгой Төслийн үйл ажиллагааны шинэчилсэн мэдээллийг хүргэж байна.

Давсан Толгой-4 цооногийн ("ДТ-4" гэх) туршилтын анхны үр дүнгийн үнэлгээ хийгдэж дууссан. Бид тус цооногт хийгдэх шингэн хагалбарын хөтөлбөрийг боловсруулж байгаа бөгөөд цооногийн тоноглолыг хийж дуусахаар шингэн хагалбарыг гүйцэтгэх гэрээг туслан гүйцэтгэгчтэй байгуулж байна. ДТ-4 цооногийн туршилт 2011 оны 09 дүгээр сарын 3-13 өдрүүдэд хийгдсэн бөгөөд тосны шинжилгээний үр дүнг 2011 оны 09 дүгээр сарын 23-нд хүлээн авлаа.

Цооногийн туршилтыг 1785-1801 метрийн гүнд байгаа Доод Цагаанцавын формацид ялгасан судалгааны үндсэн хэсэгт, мөн 1,838- 1,842 метрт байгаа хоёр дахь хэсэгт тус тус гүйцэтгэсэн.

Туршилтын үндсэн хэсэгт шавхалт хийх явцад усны хольцгүй, 42.5° API үзүүлэлттэй (API- Америкийн Нефтийн Институт, АНИ-ын нягтын нэгж) 2 литр газрын тос ялгарсан бөгөөд тосны байгалийн ундаргын хэмжээ нь өдөрт 2 баррель байсан. XIX талбай дахь Тосон уулын ордын Доод Цагаанцавын агуулагч давхаргаас тос олборлож буй цооногуудын хувьд тосны байгалийн ундарга бага байх нь хэвийн үзэгдэл бөгөөд эдгээр цооногуудын олборлолтыг усан хагалбар хийж, эрчимжүүлэх шаардлагатай байдаг. Хэдийгээр бид Давсан Толгойн Доод Цагаанцавын агуулагч давхаргын байгалийн ундарга багавтар байна гэж үзэж байгаа ч Дээд Цагаанцавын дээд хэсгийн эртний голын хөндийн формаци дахь өндөр нүх сүвшил, нэвчүүлэмж зэргээс шалтгаалж байгалийн ундаргын хэмжээ нэмэгдэх магадлалтай гэж үзэж байна.

Туршилтын хоёр дахь үе буюу 1,838-1,842 метрт байгаа формациас ямар нэгэн шингэн илрээгүй. Даралтын анхдагч мэдээллээс харахад тус үе нь нэвчүүлэмж багатай бөгөөд усан хагалбар хийх шаардлагыг хангахгүй болохыг харуулсан.

ДТ-4 цооног нь гүдэн бүтцийн баруун зах дээр байрладаг. Давсан Толгойд хийгдсэн 3 хэмжээст судалгааны нэгтгэсэн үр дүнгээр ДТ-4 цооногийн түвшнээс 25 метрийн өндөрт байрлах гүдэн бүтцийн оройн дагуу хийх судалгааны нэмэлт байрлалыг ялгасан.

Цооногийн үйлчилгээний өрмийг одоо туршилт хийгдэж байгаа ДТ-8 цооног руу нүүлгэсэн. Тус цооногийн туршилтын дараа ДТ-11 цооногт туршилт хийхээр төлөвлөж байна.

Петро Матад Компанийн Ерөнхий Гүйцэтгэх Захирал Даглас МакГэй хэлэхдээ "Бид ДТ-4 цооногийн туршилтаар Давсан Толгойн гүнзгий хэсэгт агуулагч давхаргын шинж чанарын талаар чухал мэдээлэлтэй боллоо. Ус агуулаагүй тос илэрсэн нь ДТ-4 цооногийн тосны хуримтлалыг цаашид судалж, туршихад түлхэц болж байна. ДТ-4 цооногт ялгасан Доод Цагаанцавын агуулагч давхаргын шинж чанарууд нь өнгөрсөн хугацаанд XIX талбайд хийгдсэн олборлолтын мэдээлэлтэй уялдаж байгаа юм. XIX талбайн дөрвөөс бусад бүх цооногт шингэн хагалбар хийгдсэн бөгөөд шингэн хагалбар хийснээр олборлолтыг маш сайн эрчимжүүлдэг гэж үздэг.

"Цаашилбал, 42.5° API үзүүлэлттэй, өндөр чанарын тос илэрснээр газрын тосны чанар Давсан Толгойн хэмжээнд харилцан адилгүй гэж бидний өмнөх мэдээлэлдээ дурдаж байсныг баталж байна. ДТ-1 цооногоос гаргаж авсан тосны эцсийн шинжилгээгээр 2011 оны 08 дугаар сарын 31-нд мэдээлсэн API үзүүлэлт нь 26°API хүрээд байгаа юм. Компанийн ДТ-1 болон ДТ-4 цооногийн эдгээр үр дүнгүүдийг Петро Чайна компанийн XIX талбайд тогтоогдсон 38°API дундаж үзүүлэлттэй харьцуулахад Тосон Уулын ордын тос үүсэх гал зуухнаас

тэжээгдэж буй агуулагч давхаргуудад дундаас өндөр чанарын газрын тос илэрэх боломжтой байгаа нь тодорхой байна.”

Энэхүү мэдээлэлд агуулагдсан техникийн мэдээллийг Компанийн Хайгуулын Менежер Доктор Жеймс Күүган хянасан болно. Доктор Күүган нь Хойд Америк, олон улсын хайгуул болон ашиглалтын чиглэлээр 29 жил ажилласан туршлагатай газрын тосны геологич юм. Тэрээр Америкийн Газрын Тосны Геологичдын Холбоо болон Америкийн Геологийн Нийгэмлэгийн гишүүн юм.

Петро Матад Лимитедийн тухай

Петро Матад нь Монгол Улсад газрын тосны хайгуул хийх, цаашид ашиглалт, үйлдвэрлэл явуулах зорилго бүхий группын толгой компани юм. Тус групп нь Монгол Улсын Засгийн газартай Бүтээгдэхүүн Хуваах гурван гэрээг дангаар байгуулан ажиллаж байна. Группын үндсэн хөрөнгө нь Монгол орны зүүн хэсэгт орших 10,340 км² талбай бүхий газрын тосны Матад ХХ талбайн Бүтээгдэхүүн Хуваах Гэрээ (“БХГ” гэх) юм. Үлдсэн хоёр талбай болох IV ба V талбайд нь Монгол орны төв хэсэгт оршдог бөгөөд хоёр талбай нийтдээ 71,040 км² талбайг хамарна.

Петро Матад Лимитед нь 1483V компанийн бүртгэлийн дугаартайгаар Мэний Аралд (Isle of Man) аралд үүсэн байгуулагдсан. Албан ёсны бүртгэлтэй төв байр нь Виктори Хаус, Проспет Хилл, Даглас, Айл эф Мэн, Ай Эм 1, 1ИКью (Victory House, Prospect Hill, Douglas, Isle of Man, IM1 1EQ)-д байрладаг.

Нэмэлт мэдээллийг:

Петро Матад Лимитед
Ерөнхий Гүйцэтгэх Захирал – Даглас Ж. МакГей (Douglas J. McGay)
+976 11 331099

Уэстхауз Секьюритиз Лимитед
Ричард Бэти/Питр Нортон (Richard Baty/Petre Norton)
+44 (0)20 7601 6100